



**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ**

**“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-Д ТУСГАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2025 он**

ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГОД ТУСГАГДСАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

/2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар/

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яаманд хамаарах Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хэрэгжилтэд 2025 оны 08 дугаар сарын 30-ны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын 2025 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Гурав. Хяналт-шинжилгээний үр дүн

Монгол Улсын Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын баримт бичигт Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “...Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжүүлэх, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний тоо, хүртээмжийг нэмэгдүүлж, тоон гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх” тухай 1 зорилтын хүрээнд 1 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд үнэлгээг уг зорилтын хүрээнд хийлээ.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь дээрх зорилтын хүрээнд байгууллагын стратеги төлөвлөгөө, яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нарийвчлан тусгаж олон арга хэмжээг төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд 2025 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар дээрх зорилтын биелэлт 100 хувьтай гэж дүгнэлээ.

Шинэ сэргэлтийн бодлогын баримт бичгийн 6.1.1-д “Цахим үндэстэн” болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг задалж үзвэл:

1.Нийтийн мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд Үндэсний дата төвийн сервер, тоног төхөөрөмжийг олон улсын чиг хандлагад

нийцүүлэн өргөтгөн сайжруулж, төр, хувийн хэвшлийн хамтарсан үүлэн дэд бүтцийг нэвтрүүлэн, сүлжээний төхөөрөмжүүдийг виртуалчилан удирдах боломжийг бүрдүүлсэн.

2.Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д төрийн 173, хувийн хэвшлийн 465 байгууллагын 638 үйлчилгээг холбож, 4,3 тэрбум үйлчилгээг амжилттай дуудсан байна.

3.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ийн үйл ажиллагаанд нэмэлт хөгжүүлэлт хийж, 2023 онд “e-mongolia 3.0”, 2024 онд “e-mongolia 4.0” хувилбарыг тус тус хэрэглээнд нэвтрүүлж, 2025 онд хиймэл оюунд суурилсан виртуал оператор бүхий “e-mongolia 5.0” хувилбарыг 2025.09.20-нд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn) нь e-Mongolia (иргэн), e-business.mn (хуулийн этгээд), lavlagaa.e-mongolia.mn (үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд), operator.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ), kiosk.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ), мобайл аппликейшн гэсэн 6 суваг ашиглан иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж байна. Тус системд 2,0 сая хэрэглэгч бүртгүүлж, 87 байгууллагын 1263 үйлчилгээг холбон, 78 сая удаагийн үйлчилгээг амжилттай дамжуулан 1,5 их наяд төгрөгийн шууд бус зардлыг хэмнэсэн.

Мөн хөдөө орон нутаг, алслагдсан сум, суурин газар болон хилийн чанадад байгаа ард иргэд, байгууллагуудад төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг 2023 онд байгуулж, түүний салбар, харьяа төрийн үйлчилгээний “ХУРДАН” цэгийг нийслэлд 145, орон нутагт 332, хилийн чанад дахь 31 улсын 47 байршил, нийт 524 цэгээр дамжуулан 43 байгууллагын 451 үйлчилгээг нийт 1,3 сая гаруй хүн, хуулийн этгээдэд үзүүлээд байна. Нийслэл, орон нутгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” киоск машин байршуулах ажлын хүрээнд нийслэлд 150, орон нутагт 287, нийт 437 киоск машин байршуулсан.

4.Иргэнийг таньж баталгаажуулах зорилготой танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-д тоон гарын үсгийн модулийг холбож, иргэн, хуулийн этгээдийг тоон гарын үсгээр дамжуулан таних боломжийг бүрдүүлсэн ба 2025 оны эхний хагас жилийн байдлаар уг системд нийт 2,1 хэрэглэгч бүртгүүлж, төрийн 98 байгууллагын 188 систем, хувийн хэвшлийн 276 байгууллагын 325 систем, нийт 374 байгууллагын 513 системийг холбосон.

5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийг хуульд заасан үндэслэл, журам, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулна гэж заасны дагуу мэдэгдэл хүргэх системийг хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, үндэсний цахим шуудан, хувийн цахим шуудангаар дамжуулан 2023 оны 05 дугаар сараас хойш нийт 43,1 сая мэдэгдлийг иргэнд хүргэсэн.

6.Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлж, албан бичиг солилцооны дундын систем “DocX”-ийг хөгжүүлэн, 5000 гаруй байгууллагын ашигладаг 17 албан бичиг боловсруулалтын системтэй холбож, 2858 байгууллага холбогдон 220,576 бичиг илгээн, 258,850 бичиг хүлээн авсан байна.

7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Төрийн их өгөгдөл бүрдүүлэх, бодлого, шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, хүртээмжтэй болгох бодлогын хүрээнд төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (<http://opendata.gov.mn/>) 2.0 хувилбарыг хөгжүүлж нэвтрүүлсэн. 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар тус системд 57 байгууллага, 691 төрлийн нээлттэй өгөгдөл байршуулахаас 55 байгууллага 4412 өгөгдлийн бүрдэл

бүхий 10345 файлыг машинд уншигдах форматаар байршуулж, 33215 өгөгдөл татаад байна.

8.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4.27 дахь заалтад “мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг байнга ил тод, нээлттэй байршуулна.” гэж заасны дагуу судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан, зөвлөх үйлчилгээний тайлангийн нэгдсэн сан үүсгэж, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байлгах Үндэсний судалгааны нэгдсэн платформ (sudalгаа.gov.mn)-ыг ашиглалтад оруулж, 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар 2254 судалгааг татаж авах боломжтойгоор байршуулсан. гэж тус тус тайлагнасан байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2021 оны “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 6.3.3-т “Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг тор хугацаанд зогсоож, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна” зорилтын биелэлтийг “Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй байлгах хүрээнд төрийн үйлчилгээний “e-business.mn”-ийн талаар тайлагнасан байна. Тус систем нь бизнес эрхлэгч хүн бүрд зориулсан, хуулийн этгээд үүсгэн байгуулахаас эхлээд бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, олон төрлийн зөвшөөрөл хүсэх, сунгах, байгууллагын лавлагааг нэг дороос авах боломжийг бүрдүүлэх зорилготой. Энэхүү систем 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр нээлтээ хийж одоогийн байдлаар иргэн, Аж ахуй нэгжид 88 төрийн байгууллагын 953 үйлчилгээг цахимаар хүргэн ажиллаж байна.

1. Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn-тэй хамтран зөвшөөрлийн нэгдсэн санд байгаа зөвшөөрлийн төлөвийн мэдээллийг e-mongolia мобайл аппликейшний “Төрд байгаа мэдээлэл” цэсэд харуулахаар хөгжүүлэлтийг хийсэн.

2. Мөн license.mn системийг e-business.mn системд нэгтгэн Зөвшөөрлийн цахим систем цонхонд харуулах хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн” гэж тус тус тайлагнасан байна.

Дөрөв. Дүгнэлт

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын тус яамнаас хариуцан ажиллах 2 зорилтын хэрэгжилтэд 2025 оны байдлаар хяналт-шинжилгээ хийхэд 100 хувийн биелэлттэй хэрэгжиж байгаа буюу үр дүнтэй ажиллаж байна гэж үзлээ. Тодруулбал бодлогын баримт бичгийн үйл ажиллагааны хүрэх түвшинг “төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох “E-Mongolia”-д нэвтрүүлсэн төрийн 57 байгууллагын 563 үйлчилгээг 1000-д хүргэн нэмэгдүүлж, цахим гэрээ хэлцлийг байгуулах нөхцөл бүрдэж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдсэн байх”-аар төлөвлөсөн.

2025 оны 09 дүгээр сарын байдлаар дээрх төлөвлөлтөд тусгасан системийн үйлчилгээний тоог 1000-д хүргэх биелэлт даван биелж нийт системд 2,0 сая хэрэглэгч бүртгүүлж, 87 байгууллагын 1263 үйлчилгээг холбон, 78 сая удаагийн үйлчилгээг амжилттай дамжуулан 1,5 их наяд төгрөгийн шууд бус зардлыг хэмнэсэн. Энэ мэтээр төрийн үйлчилгээ цахимаар иргэдэд хүрэх нөхцөл хангалттай биелэгдэж байгаа сайн үр дүнтэй байна.

Түүнчлэн иргэдэд цахимаар үйлчилгээг хүргэх үүднээс төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” киоск машин байршуулах ажлын хүрээнд нийслэлд 150, орон нутагт 287, нийт 437 киоск машин байршуулсан байх ба иргэд киоск машинаар төрийн үйлчилгээг оочир дараалалгүйгээр авах нөхцөл бүрдэх ажил амжилттай хэрэгжилттэй гэж үзэхээр байна.

Түүнчлэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам нь 2024 онд төрийн үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэх ажлын хүрээнд 109 хуульд өөрчлөлт оруулах ажлыг амжилттай хэрэгжүүлж эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Мөн салбарын томоохон хуулийг дагаж мөрдөх олон журмыг батлуулан ажиллаж байгааг дурдах нь зүйтэй байна.

Мөн Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй байлгах хүрээнд төрийн үйлчилгээний “e-business.mn”-ийн талаар тайлагнасан байна. Тус систем нь бизнес эрхлэгч хүн бүрд зориулсан, хуулийн этгээд үүсгэн байгуулахаас эхлээд бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, олон төрлийн зөвшөөрөл хүсэх, сунгах, байгууллагын лавлагааг нэг дороос авах боломжийг бүрдүүлэх зорилготой. Энэхүү систем 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр нээлтээ хийж одоогийн байдлаар иргэн, Аж ахуй нэгжид 88 төрийн байгууллагын 953 үйлчилгээг цахимаар хүргэн ажиллаж байна.

Иймээс тус бодлогын хэрэгжилтүүд үр дүнтэй сайн хэрэгжиж байгаа боловч тайлангийн хугацаа, тайлагнах хэлбэр зэрэгтэй холбоотойгоор дараах зөвлөмжийг үүгээр хүргүүлж байна.

Тав. Санал, зөвлөмж.

1. Биелэлтийг гаргахдаа ҮР ДҮН, НОТЛОХ БАРИМТ-д тулгуурлах зарчмыг мэргэжилтэн болон нэгжийн удирдлагууд мөрдлөг болгон ажиллах.
2. Биелэлт нь тухайн байгууллага, нэгж, ажилтан бүрийн хийсэн ажлын үр дүнг харуулдаг тул хугацаа, агуулгыг анхаарах.
3. Төлөвлөгөөнд туссан боловч салбарын бусад байгууллагаас хамаарах ажилд анхаарал хандуулж, хамтран ажиллах.
4. Биелэлтийг ирүүлэхэд үг үсэг, утга найруулгын алдаагүй, 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүйгээр хууль, журамд заасан хугацааг харгалзан үзэж тайлагнаж хэвших.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны ... сарынны
өдрийнтоот албан бичгийн дүгээр хавсралт

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМ
"ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО"-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр

Уг

Д/д	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
6.1.1	"Цахим үндэстэн" болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д 87 байгууллагын 1263 үйлчилгээг нэгтгэн, 2 сая хэрэглэгчид 84 сая удаагийн үйлчилгээ үзүүлж, иргэдийг цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөлийг бүрдүүлсэн.	1.Нийтийн мэдээллийн дэд бүтцийн бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд үндэсний дата төвийн сервер, тоног төхөөрөмжийг олон улсын чиг хандлагад нийцүүлэн өргөтгөн сайжруулж, төр, хувийн хэвшлийн хамтарсан үүлэн дэд бүтцийг нэвтрүүлэн, сүлжээний төхөөрөмжүүдийг виртуалчилан удирдах боломжийг бүрдүүлсэн. 2.Төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д төрийн 173, хувийн хэвшлийн 465 байгууллагын 638 үйлчилгээг холбож, 4,3 тэрбум үйлчилгээг амжилттай дуудсан байна. 3.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn)-ийн үйл ажиллагаанд нэмэлт хөгжүүлэлт хийж, 2023 онд “e-mongolia 3.0”, 2024 онд “e-mongolia 4.0” хувилбарыг тус тус хэрэглээнд нэвтрүүлж, 2025 онд хиймэл оюунд суурилсан виртуал оператор бүхий “e-mongolia 5.0” хувилбарыг 2025.09.20-нд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (e-mongolia.mn) нь e-Mongolia (иргэн), e-business.mn (хуулийн этгээд), lavlagaa.e-mongolia.mn (үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд), operator.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ), kiosk.e-mongolia.mn (ХУРДАН төрийн үйлчилгээ), мобайл аппликейшн гэсэн 6 суваг ашиглан иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж байна. Тус системд 2,0 сая хэрэглэгч бүртгүүлж, 87 байгууллагын 1263 үйлчилгээг холбон, 78 сая удаагийн үйлчилгээг амжилттай дамжуулан 1,5 их наяд төгрөгийн шууд бус зардлыг хэмнэсэн. Мөн хөдөө орон нутаг, алслагдсан сум, суурин газар болон хилийн чанадад байгаа ард иргэд, байгууллагуудад төрийн үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй хүргэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг 2023 онд байгуулж, түүний салбар, харьяа төрийн үйлчилгээний “ХУРДАН” цэгийг нийслэлд 145, орон нутагт 332, хилийн чанад дахь 31 улсын 47 байршил, нийт 524 цэгээр дамжуулан 43 байгууллагын 451 үйлчилгээг нийт 1,3 сая гаруй хүн, хуулийн этгээдэд үзүүлээд байна. Нийслэл, орон нутгийн хэмжээнд төрийн цахим үйлчилгээний “ХУРДАН” киоск машин байршуулах ажлын хүрээнд нийслэлд 150, орон нутагт 287, нийт 437 киоск машин байршуулсан. 4.Иргэнийг таньж баталгаажуулах зорилготой танилт, нэвтрэлтийн систем (ДАН)-д тоон гарын үсгийн модулийг холбож, иргэн, хуулийн этгээдийг тоон гарын үсгээр дамжуулан таних боломжийг бүрдүүлсэн ба 2025 оны эхний хагас жилийн байдлаар уг системд нийт 2,1 хэрэглэгч бүртгүүлж, төрийн 98 байгууллагын 188 систем, хувийн хэвшлийн 276 байгууллагын 325 систем, нийт 374 байгууллагын 513 системийг холбосон. 5.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээллийг хуульд заасан үндэслэл, журам, эсхүл мэдээллийн эзний зөвшөөрлөөр танилцах, ашиглах, эсхүл гуравдагч этгээдэд дамжуулна гэж заасны дагуу мэдэгдэл хүргэх системийг хөгжүүлж, төрийн үйлчилгээний нэгдсэн систем, үндэсний цахим шуудан, хувийн цахим шуудангаар дамжуулан 2023 оны 05 дугаар сараас хойш нийт 43,1 сая мэдэгдлийг иргэнд хүргэсэн. 6.Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлж, албан бичиг солилцооны дундын систем “DocX”-ийг хөгжүүлэн, 5000 гаруй байгууллагын ашигладаг 17 албан бичиг боловсруулалтын системтэй холбож, 2858 байгууллага холбогдон 220,576 бичиг илгээн, 258,850 бичиг хүлээн авсан байна. 7.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг, Төрийн их өгөгдөл бүрдүүлэх, бодлого, шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд ил тод, хүртээмжтэй болгох бодлогын хүрээнд төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (http://opendata.gov.mn/) 2.0 хувилбарыг хөгжүүлж нэвтрүүлсэн. 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар тус системд 57 байгууллага, 691 төрлийн нээлттэй өгөгдөл байршуулахаас 55 байгууллага 4412 өгөгдлийн бүрдэл бүхий 10345 файлыг машинд уншигдах форматаар байршуулж, 33215 өгөгдөл татаад байна. 8.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.4.27 дахь заалтад “мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайланг байнга ил тод, нээлттэй байршуулна.” гэж заасны дагуу судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан, зөвлөх үйлчилгээний тайлангийн нэгдсэн сан үүсгэж, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байлгах Үндэсний судалгааны нэгдсэн платформ (sudalгаа.gov.mn)-ыг ашиглалтад оруулж, 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн байдлаар 2254 судалгааг татаж авах боломжтойгоор байршуулсан.	100

**Монгол Улсын Их Хурлын 2021 оны "Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай" 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаас
тус яаманд хамаарах хэсгийн биелэлт**

д/д	Зорилт	Үйл ажиллагаа, арга хэмжээ	Хэрэгжилт ийн хувь
6.3.3.	Төрийн хяналт, шалгалтын давхардсан тогтолцоог цэгцэлж, төлөвлөгөөт шалгалтыг тор хугацаанд зогсоож, төрийн байгууллагаас шаарддаг тусгай зөвшөөрөл, техникийн нөхцөлийн тоог бууруулна.	Тусгай зөвшөөрлийн цахим нэгдсэн санг бүрдүүлж, нээлттэй байлгах: Төрийн үйлчилгээний e-business.mn систем нь бизнес эрхлэгч хүн бүрд зориулсан, хуулийн этгээд үүсгэн байгуулахаас эхлээд бүх төрлийн үйлчилгээг цахимжуулж, олон төрлийн зөвшөөрөл хүсэх, сунгах, байгууллагын лавлагааг нэг дороос авах боломжийг бүрдүүлэх зорилготой. Тус систем 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр нээлтээ хийж одоогийн байдлаар иргэн, ААН-д 88 төрийн байгууллагын 953 үйлчилгээг цахимаар хүргэн ажиллаж байна. 1.Зөвшөөрлийн нэгдсэн систем license.mn-тэй хамтран зөвшөөрлийн нэгдсэн санд байгаа зөвшөөрлийн төлөвийн мэдээллийг e-mongolia мобайл аппликейшний "Төрд байгаа мэдээлэл" цэсэд харуулахаар хөгжүүлэлтийг хийсэн. 2.Мөн license.mn системийг e-business.mn системд нэгтгэн Зөвшөөрлийн цахим систем цонхонд харуулах хөгжүүлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%